



Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



2026 он

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд Төв аймагт 2025 онд шинээр хэрэгжүүлэх ажил төлөвлөгдөөгүй бөгөөд өмнөх оноос дамжин хэрэгжиж буй 6 төсөл, арга хэмжээнд нийт 9,482.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдан бүрэн олгогдсон байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ:



БОЛОВСРОЛЫН САЙДЫН БАГЦ

- **Нийт төсөв:** 4,843.0 сая ₮
- **Ажил:** 2 Сургууль, 1 Цэцэрлэгийн барилга



ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН БАГЦ

- **Нийт төсөв:** 4,639.2 сая ₮
- **Ажил:** 1 Авто зам, 1 Төмөр бетон гүүр, 1 Үерийн далан

Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид олгосон нийт санхүүжилт

Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн	Гүйцэтгэгчид		Гүйцэтгэлийн хувь
		Олговол зохих	Санхүүжсэн	
Цэцэрлэгийн барилга, 150 ор /Төв, Баянцогт сум/	2,573.9	2,140.4	917.0	38.9
Үерийн далан, 3.8 км /Төв, Лүн сум/	4,754.4	4,482.8	2,459.7	53.7
Сургуулийн барилга, 320 суудал /Төв, Заамар сум, Хайлааст баг/	6,194.7	5,977.9	5,469.1	91.3
Сургуулийн барилга, 320 суудал /Төв, Борнуур сум/	5,483.8	5251.9	2,834.3	54.8
Сумын доторх болон улсын чиглэлийн хатуу хучилттай авто замаас сум хүртэлх хатуу хучилттай авто зам /Төв, Баяндэлгэр сум/	2,109.9	2069.8	1956.9	100
Туул голын хойд болон дунд салаан дээрх төмөр бетон гүүрийн зураг төсөв, барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх /Төв, Алтанбулаг сум/	2,374.8	846.0	676.0	100
		1,483.63	1,045.3	70.5
Нийт дүн	23,491.5	22,252.4	15,358.2	

Туул голын хойд болон дунд салаан дээрх төмөр бетон гүүр хийх ажил (Төв аймаг, Алтанбулаг сум)

- ◇ 2019 онд Туул голын хойд болон дунд салаан дээрх төмөр бетон гүүр гэж 2,374.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тусгагдсан.
- ◇ 2024 онд Туул голын төмөр бетон гүүрний зураг төсөв, барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх болгон өөрчилсөн.
- ◇ 2025 онд 950.9 сая төгрөгөөр зураг, төсөв хийгдэж, 1,423.9 сая төгрөгөөр 1.2 км замын суурь далангийн ажил хийсэн байна.
- ◇ Зам тээврийн хөгжлийн төвийн 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 287/2025 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр нийт төсөвт өртгийг 38,336.0 сая төгрөгөөр хянаж, баталгаажуулсан байна.

Цаашид тус зам, гүүрийн ажлын үлдэгдэл төсөв бүрэн батлагдаж, хэрэгжих эсэх нь тодорхойгүй болсон байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- ⇒ Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд заасан хугацаанд 2 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн, 4 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжиж байна.
- ⇒ Тайлант онд шинээр эхлэх төсөл арга хэмжээ батлагдаагүй тул худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй, 2024 онд батлагдсан Баянцогт сумын 150 ортой цэцэрлэгийн барилгын ажлын худалдан авах ажиллагааг 2025 онд он дамжин зохион байгуулсан байна.
- ⇒ Баянцогт сумын 150 ортой цэцэрлэгийн барилга нь “Төсвийн тухай” хуульд магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй батлагдсанаас төсөвт өртөгт 976.6 сая төгрөгийн зөрүү гарсан байна.
- ⇒ Зураг, төсөвгүй барилгын ажилд санхүүжилт баталснаас Баянцогт сумын цэцэрлэгийн зөвхөн барилга угсралтын ажилд гэрээ байгуулагдаж, барилгын гадна шугам, сүлжээ, тохижилтгүй, бүрэн ашиглалтад орох боломжгүй болсон байна.
- ⇒ Туул голын төмөр бетон гүүрний зураг төсөв, барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх ажлын төсөвт өртөг нь магадлалын ерөнхий дүгнэлтээр 38,336.0 сая төгрөг болсноор цаашид хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй болсон байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн аймгийн Засаг дарга танаа зөвлөх нь:

- ⇒ Цаашид зураг, төсөв нь магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах

Нэгдсэн тайланд тусгуулахаар Үндэсний аудитын газарт хүргүүлэх санал:

- ⇒ Баянцогт сумын 150 ортой цэцэрлэгийн барилгын ажилд 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан 2,800.0 сая төгрөг болон магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан 3,776.6 сая төгрөгийн зөрүү 976.6 сая төгрөгийг шийдвэрлэж, тус барилгын ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтад оруулахад шаардлагатай арга хэмжээг авах талаар нэгдсэн тайланд тусгах